БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БӨА-2022/169/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2022 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: Khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: М.Айнур<br>Утас: 94159291 Цахим хаяг: ainurmarkh@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....12
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....14
3. Аудитын тайлан....16
3.1 Ерөнхий зүйл ....16
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....17
3.4 Материаллаг байдал ....17
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ....17
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ....19
3.8 Аудитын гол асуудал ....19
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....20
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....20
4. Аудитын илрүүлэлт ....20
4.1 Залруулсан алдаа....20
4.2 Төлбөрийн акт....20
Байхгүй ....20
4.3 Албан шаардлага ....20
Байхгүй ....20
4.4 Зөвлөмж ....20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....21

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2022.02.21 № 87
танай ____________-ны № ____________-т

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН
БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
Т.ЗАМАНБЕК ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Улсын бүртгэлийн хэлтэс-Дүгнэлт

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,439,420.20** | **78,117,967.30** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | - | - |
| 31120 | Гадаад валют | - | - |
| 31130 | Нэмэлт санхүүжилт | - | - |
| 31140 | Касс арилжааны банк | - | - |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **3121** | **Төгрөг** | - | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | - |
| 31212 | Монгол банкин дахь харилцах | - | - |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | - | - |
| 31214 | Бусад төсөл, нөөцийн харилцах | - | - |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | - | - |
| 31216 | Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк | - | - |
| **33** | **АВЛАГА** | - | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | - |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | - |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | - |
| 33400 | Зээлийн хүүгийн авлага | - | - |
| **335** | **Бусад авлага** | - | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | - |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 43,439,420.20 | 78,117,967.30 |
| **351** | **Түүхий эд материал** | 10,975,612.30 | 16,037,469.40 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 10,975,612.30 | 16,037,469.40 |
| 35130 | Эм боох материал | - | - |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | - | - |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 4,159,063.90 | 5,741,053.90 |
| **354** | **Хангамжийн материал** | 28,304,744.00 | 56,339,444.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,990,500.00 | 2,541,800.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 25,085,785.00 | 33,332,785.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 650,000.00 | 1,282,500.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | - | - |
| 35450 | Барилгын засварын материал | - | - |
| 35460 | Хүнсний материал | - | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 578,459.00 | 19,182,359.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | - | - |
| 35600 | Мал амьтад | - | - |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **43,971,113.02** | **158,710,971.08** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 43,971,113.02 | 158,710,971.08 |
| 391 | Газар | - | - |
| **392** | **Биет хөрөнгө** | 43,971,113.02 | 158,710,971.08 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 28,000,000.00 | 28,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (28,000,000.00) | (28,000,000.00) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 148,337,728.50 | 219,838,368.50 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (111,892,921.88) | (66,413,467.95) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 22,666,030.00 | 22,666,030.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (15,139,723.60) | (17,379,959.47) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | - | - |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | - | - |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | - | - |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | - | - |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | - | - |
| 39217 | Ном | - | - |
| **393** | **Биет бус хөрөнгө** | - | - |
| 39301 | Програм хангамж | 4,608,250.00 | 4,608,250.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (4,608,250.00) | (4,608,250.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | - | - |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **87,410,533.22** | **236,828,938.38** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **413** | **Өглөг** | - | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | - |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | - |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | - | - |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | - | - |
| 41350 | Зээлийн хүүгийн өглөг | - | - |
| **4136** | **Бусад өглөг** | - | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | - |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **87,410,533.22** | **236,828,938.38** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 87,410,533.22 | 236,828,938.38 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | - | - |
| 51101 | Өмч: - төрийн | - | - |
| 51102 | - хувийн | - | - |
| 51103 | - хувьцаат | - | - |
| 51104 | Халаасны хувьцаа | - | - |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал | - | - |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | - | - |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 87,410,533.22 | 236,828,938.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 69,180,471.33 | 87,410,533.22 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 18,230,061.89 | 149,418,405.16 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | - | - |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | - | - |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | - | - |
| 51600 | Нөөцийн сан | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **87,410,533.22** | **236,828,938.38** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **713,879,096.56** | **825,695,610.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **51,420,096.56** | **202,371,710.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 51,420,096.56 | 202,371,710.00 |
| 120002 | Хүүгийн орлого | - | - |
| 120003 | Торгуулийн орлого | - | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 51,420,096.56 | 202,371,710.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 51,420,096.56 | 202,371,710.00 |
| 120005 | Түрээсийн орлого | - | - |
| 120006 | Газрын тосны орлого | - | - |
| 120009 | Бусад орлого | - | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **662,459,000.00** | **623,323,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 492,247,800.00 | 524,751,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 492,247,800.00 | 524,751,900.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | - | - |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | - |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | - | - |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | - | - |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | - |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | - | - |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | - | - |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | - | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 170,211,200.00 | 98,572,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | - |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | - | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,600,000.00 | 7,435,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 164,611,200.00 | 91,137,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | - |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **695,649,034.67** | **676,277,204.84** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **695,649,034.67** | **676,277,204.84** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 694,440,091.45 | 675,546,787.84 |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 386,219,129.78 | 411,115,393.00 |
| 210101 | Үндсэн цалин | 318,857,726.78 | 327,152,628.00 |
| 210102 | Нэмэгдэл | 58,627,403.00 | 75,362,965.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,734,000.00 | 8,599,800.00 |
| 210104 | Урамшуулал | - | - |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 48,947,126.00 | 53,370,599.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 33,825,675.00 | 33,988,686.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,810,327.00 | 7,258,317.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,048,260.00 | 3,265,405.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 749,776.00 | 805,632.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,513,088.00 | 8,052,559.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 46,332,000.00 | 50,932,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | - | - |
| 210302 | Түлш, халаалт | - | - |
| 210303 | Цэвэр, бохир ус | - | - |
| 210304 | Байрны түрээс | 46,332,000.00 | 50,932,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,312,281.00 | 28,177,594.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 10,601,331.00 | 6,360,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,715,200.00 | 4,132,611.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,520,100.00 | 2,754,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 37,000.00 | 42,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,438,650.00 | 13,252,400.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | - | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 1,635,683.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | - |
| 210502 | Хоол, хүнс | - | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | - | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 584,500.00 | - |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | - |
| 210602 | Тавилга | 584,500.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | - |
| 210604 | Урсгал засвар | - | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 53,000.00 | 224,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 53,000.00 | 224,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 22,133,432.80 | 18,986,729.90 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 313,400.00 | 282,780.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 65,000.00 | 120,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 147,720.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | - |
| 210807 | Газрын төлбөр | - | - |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | - | - |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 21,285,312.80 | 18,441,949.90 |

| | | | |
|---|---|---|---|
| 210810 | Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/ | - | - |
| 210811 | Ерөнхий ба удирдлагын зардал /ТӨҮГ/ | - | - |
| 210812 | Санхүүгийн зардал /ТӨҮГ/ | - | - |
| 210813 | Бусад зардал /ТӨҮГ/ | - | - |
| 210814 | Орлогын татварын зардал /ТӨҮГ/ | - | - |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 173,858,621.87 | 112,740,471.94 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 163,363,281.00 | 91,137,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 454,950.00 | 658,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 10,040,390.87 | 20,945,471.94 |
| 210904 | Найдваргүй авлагын алдагдал | - | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,208,943.22 | 730,417.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | - | - |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 | 237,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | - | - |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | - | - |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | - | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | - |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | - | - |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | - | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | - | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 237,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 808,943.22 | 493,417.00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | - |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | - | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 808,943.22 | 493,417.00 |
| 213304 | Хөрөнгийн | - | - |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - |
| 220001 | Барилга байгууламж | - | - |
| 221001 | Их засвар | - | - |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | - |
| 223001 | Бусад хөрөнгө | - | - |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | - | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | - | - |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **18,230,061.89** | **149,418,405.16** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **18,230,061.89** | **149,418,405.16** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | | | 0.00 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **0.00** | 0.00 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 87,410,533.22 | 87,410,533.22 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **87,410,533.22** | 87,410,533.22 |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **87,410,533.22** | 87,410,533.22 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **87,410,533.22** | 87,410,533.22 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 149,418,405.16 | 149,418,405.16 |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **0.00** | **0.00** | **236,828,938.38** | 236,828,938.38 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **845,189,792.97** | **845,117,137.05** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **182,730,792.97** | **221,793,237.05** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 182,730,792.97 | 221,793,237.05 |
| 120002 | Хүүгийн орлого | | |
| 120003 | Торгуулийн орлого | | |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 182,730,792.97 | 221,793,237.05 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 182,730,792.97 | 221,793,237.05 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | | |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | | |
| 120005 | Түрээсийн орлого | | |
| 120009 | Бусад орлого | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **662,459,000.00** | **623,323,900.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 492,247,800.00 | 524,751,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 492,247,800.00 | 524,751,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | | |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 170,211,200.00 | 98,572,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,600,000.00 | 7,435,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 164,611,200.00 | 91,137,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **842,871,792.97** | **844,347,137.05** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **842,871,792.97** | **844,347,137.05** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **658,932,056.78** | **621,823,483.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 383,224,775.78 | 385,752,992.00 |
| 210101 | Үндсэн цалин | 315,740,172.78 | 301,476,727.00 |
| 210102 | Нэмэгдэл | 58,627,403.00 | 75,362,965.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,857,200.00 | 8,913,300.00 |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51,941,480.00 | 78,733,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36,810,180.00 | 64,270,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,782,800.00 | 3,615,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,026,300.00 | 2,892,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 756,600.00 | 723,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,565,600.00 | 7,231,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 46,332,000.00 | 50,932,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | |
| 210302 | Түлш, халаалт | | |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | 46,332,000.00 | 50,932,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,030,510.00 | 12,748,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,115,200.00 | 4,282,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,710,760.00 | 4,131,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,520,100.00 | 2,754,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 37,000.00 | 42,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,647,450.00 | 1,539,200.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |

| | | | |
|---|---|---|---|
| 210408 | Бараа материал акталсны зардал | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 679,500.00 | 774,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 95,000.00 | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 584,500.00 | 499,700.00 |
| 210604 | Урсгал засвар | | 275,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 53,000.00 | 224,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 53,000.00 | 224,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 852,560.00 | 662,991.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 317,840.00 | 400,991.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 65,000.00 | 120,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 147,720.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 163,818,231.00 | 91,995,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 163,363,281.00 | 91,137,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 454,950.00 | 858,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **183,939,736.19** | **222,523,654.05** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 400,000.00 | 237,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 400,000.00 | 237,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 808,943.22 | 493,417.00 |
| 213301 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 213302 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 808,943.22 | 493,417.00 |
| 213304 | Хөрөнгийн | | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 182,730,792.97 | 218,160,337.05 |
| 213401 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага | | |

| | | | |
|---|---|---|---|
| 213402 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт сумдад | | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 182,730,792.97 | 218,160,337.05 |
| 213404 | Хөрөнгийн | | |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 3,632,900.00 |
| 213501 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 213502 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгө | | |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 3,632,900.00 |
| 213504 | Хөрөнгийн | | |
| 213505 | Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт | | |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,318,000.00** | **770,000.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,318,000.00** | **770,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,318,000.00** | **770,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,318,000.00 | 770,000.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | |
| 223001 | Бусад хөрөнгө | | |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | | |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 2,318,000.00 | 770,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,318,000.00)** | **(770,000.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 524,751,900.00 | 524,258,483.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 524,751,900.00 | 524,258,483.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 524,435,100.00 | 524,021,483.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 383,328,000.00 | 383,232,992.00 |
| 210101 | Үндсэн цалин | 322,534,300.00 | 298,956,727.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 52,081,700.00 | 75,362,965.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,712,000.00 | 8,913,300.00 |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 78,418,000.00 | 78,418,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 63,955,600.00 | 63,955,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,615,600.00 | 3,615,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,892,500.00 | 2,892,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 723,100.00 | 723,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,231,200.00 | 7,231,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 46,332,000.00 | 46,332,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | |
| 210302 | Түлш, халаалт | | |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | 46,332,000.00 | 46,332,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,754,300.00 | 12,748,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,284,000.00 | 4,282,100.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,131,000.00 | 4,131,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,754,000.00 | 2,754,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 42,500.00 | 42,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,542,800.00 | 1,539,200.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,545,000.00 | 1,544,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 770,000.00 | 770,000.00 |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 500,000.00 | 499,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 275,000.00 | 275,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 228,800.00 | 224,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 228,800.00 | 224,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 971,000.00 | 662,991.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 429,000.00 | 400,991.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 280,000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 120,000.00 | 120,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 120,000.00 | 120,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 22,000.00 | 22,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | | |
| 210808 | Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж | | |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 858,000.00 | 858,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 858,000.00 | 858,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 316,800.00 | 237,000.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 316,800.00 | 237,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | | |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | | |

| | | | |
|---|---|---|---|
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | | |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 316,800.00 | 237,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 524,751,900.00 | 524,258,483.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 524,751,900.00 | 524,258,483.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 524,751,900.00 | 524,258,483.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | | |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 36.00 | 36.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 27.00 | 27.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 5.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **36.00** | **36.00** |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 28.00 | 28.00 |
| 650002 | Төрийн тусгай албан хаагч (ТТ) | | |
| 650003 | Ажлын албаны албан хаагч (АА) | | |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | | |
| 650005 | ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ) | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн ïйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | | |
| 650007 | Мэргэжлийн боловсролын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮМБ) | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 5.00 | 5.00 |
| 650010 | Гэрээт ажилтан | 3.00 | 3.00 |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **169,557,281.00** | **98,572,000.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **169,557,281.00** | **98,572,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 169,557,281.00 | 98,572,000.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 4,977,820.00 | 2,520,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | 4,977,820.00 | 2,520,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | | |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | | |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 622,180.00 | 315,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 622,180.00 | 315,000.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | - | 4,600,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | |
| 210302 | Түлш, халаалт | | |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | | 4,600,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 163,957,281.00 | 91,137,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 163,957,281.00 | 91,137,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 169,557,281.00 | 98,572,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 169,557,281.00 | 98,572,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 7,435,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 169,557,281.00 | 91,137,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зөвлөмж өгөгдөөгүй болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор М.Айнур гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01/161 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улсын бүртгэлийн хэлтэс нь улсын бүртгэлийн үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулж хэрэгжүүлэх, улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэх үйлчилгээний нээлттэй байдлыг хангахуйц үйлчилгээний стандартыг бий болгох, нэг иргэнд суурилсан нэг бүртгэл, бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бий болгож бэхжүүлэх, улсын бүртгэлийн нэгдсэн санд суурилсан үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, бүртгэлийн мэдээллийг хэрэглээнд оруулан цахим засаглалын эхлэлийг тавих, дээрх стратегийн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах удирдлага, зохион байгуулалт, хяналтын оновчтой тогтолцоог бүрдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд УБЕГ-ын бодлого, төлөвлөлтийн газраас шалгалт хийгдсэн байна. 2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд цахимаар шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баян-Өлгий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 6 гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 695.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 13.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 10.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баян-Өлгий аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 149.4 сая төгрөгөөр буюу 2.7 дахин өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | - | - | - |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 43439.4 | 78118.0 | 34678.5 |
| Үндсэн хөрөнгө | 43971.1 | 158711.0_ | 114739.8 |
| **Нийт хөрөнгө** | **87410.5** | **236828.9** | **149418.4** |
| Өр төлбөр | - | - | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 87410.5 | 236828.9 | 149418.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **87410.5** | **236828.9** | **149418.4** |

Мөнгөн хөрөнгө, авлага данс оны эцэст үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 34.7 сая төгрөгөөр өссөн нь худалдан авсан болон Ерөнхий газраас ирсэн бараа материалын зарцуулаагүй үлдэгдэл нөлөөлжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй он удаан жил болсон бараа материал байхгүй байна.

Оны эцэст бараа материалын үлдэгдлийг төрлөөр нь авч үзвэл тусгай зориулалттай материалын үлдэгдэл 5.1 сая төгрөгөөр, бэлэн бүтээгдэхүүний үлдэгдэл 1.6 сая төгрөгөөр, хангамжийн материалын үлдэгдэл 28.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. УБЕГ-аас 67.5 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй олгосныг бүртгэлд тусгасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 114.7 сая төгрөгөөр өссөн байна. Үүнд: тайлант онд төсвийн хөрөнгөөр 0.7 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг худалдан авч , УБЕГ-аас 134.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авсан. Тайлант онд 64.2 сая төгрөгийн элэгдлээ бүрэн нөхсөн 64.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ТӨБЗГ-ын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 720 дугаар тогтоолоор акталж данснаас хассан байна.

Тайлант онд ашиглаж буй үндсэн хөрөнгөд нийт 20.9 сая төгрөгийн элэгдэл байгуулсан байна. Биет бус хөрөнгийн дүнд ямар нэгэн өөрчлөлт ороогүй байна.

Өр төлбөр данс оны эхэнд үлдэгдэлгүй ба тайлант онд үйл ажиллагаатай холбоотой өр үүсгээгүй байна. Тус газарт урт хугацаат өр төлбөр байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 149.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 149.4 сая төгрөгийн үр дүнтэй гарснаас шалтгаалжээ. Засгийн газрын капиталын дүнд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 111.8 сая төгрөгөөр буюу 15.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого 32.5 сая төгрөгөөр, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 150.9 сая төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Нийт зардал өмнөх оноос 19.4 сая төгрөгөөр буюу 2.8 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, НДШ, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж, бараа материалын болон томилолтын зардал нь 0.2-24.8 сая төгрөгөөр өсөж, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, урсгал шилжүүлгийн зардал 0.5- 61.1 сая төгрөгөөр буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар үр дүн 149.4 сая төгрөг байна. Өмнөх оны үр дүнд ямар нэгэн залруулга хийгдээгүй байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улсын бүртгэлийн ерөнхий газраас тус газрын анхны төсвийг 476.3 сая төгрөгөөр баталж, төсвийн тодотголоор 524.7 сая төгрөг болгон өөрчилж, анх баталснаас 48.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 19 арга хэмжээг санхүүжүүлэхээр 524.7 сая төгрөгийн төсөв баталснаас 524.7 сая төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 524.7 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 524.3 сая төгрөгийг зарцуулжээ. Үндсэн санхүүжилтээс 0.5 сая төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 524.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос нийтдээ 221.8 сая төгрөгийн орлого төвлөрүүлж үүнээс 218.2 сая төгрөгийг улсын төсөвт, 3.6 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна. Орон нутгийн төсвийн орлогод орох торгуулийн орлого нь УБЕГ-т төвлөрсөн байсныг УБЕГ -аас ирүүлсэн бичгийг үндэслэн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 7.4 сая төгрөгийн, УБЕГ-аас Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлын хүрээнд 91.1 сая төгрөгийн, нийт 98.5 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэлт дансаар хүлээн авсан байна.

Үүнээс цалин хөлсөнд 2.5 сая төгрөгийг, НДШ-ийн зардалд 0.3 сая төгрөгийг, байр ашиглалттай холбоотой зардалд 4.6 сая төгрөгийг, бараа үйлчилгээний бусад зардалд 91.1 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улсын бүртгэлийн хэлтсийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх

дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улсын бүртгэлийн хэлтэс нь 2021 онд 107 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 524.7 сая төгрөгийн 105 мэдээллийг хугацаандаа байршуулсан, 2 мэдээллийн хугацаа болоогүй байна. Өссөн дүнгээр Шилэн дансны 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 46.5 сая төгрөгийн худалдан авалтыг, улсын төсөвт төвлөрүүлсэн орлогыг тайлагнасан байна. Шилэн дансны мэдээллийг оруулсан байдлын хэрэгжилтийн хувь 98.1 хувьтай байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудтай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар итгэл үзүүлсэн ба зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх эсвэл анхаарал татахуйц асуудал гараагүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил дутагдал гараагүй болно.

4.1 Залруулсан алдаа

Байхгүй

4.2 Төлбөрийн акт

Байхгүй

4.3 Албан шаардлага

Байхгүй

4.4 Зөвлөмж

Зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | УБХ | | | | | | | | | | |